



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТҮҮХЭН ТАНИЛЦУУЛГА

БНМАУ-ын бага хурлын тэргүүлэгчдын 1941 оны 12-р сарын 11-ны өдрийн 81-р тогтоолоор Дундговь аймаг байгуулагдахад Төв, Дорноговь, Өмнөговь аймгаас тасарч 120.0 мянган га нутаг дэвсгэрт 18 сум, 24.0 мянган хүн амтай “Шарангад аймаг” нэртэй байгуулагдсан түүхтэй.

Дундговь аймгийн тухайн үеийн анхны 12 албан газрын нэг нь Мал эмнэлгийн тасаг байсан. 1944-1954 онд МАА хэлтсийн зоо-мал эмнэлгийн тасаг, 1962 онд аймгийн Ардын депутатын хурлын Гүцэтгэх захиргааны Хөдөө аж ахуйн хэлтсийг өргөтгөн ХААУГазар багуулсан. 1967 онд хуралдсан МАХН-ын төв хорооны 3-р бүгд хурлын шийдвэрийн дагуу 11 дүгээр сарын 27 өдөр аймгийн ХАА нэгдлийн зөвлөлийг 2 хэлтэс 25 хүний орон тоотойгоор батлан ажиллуулж эхэлсэн. Аймгийн ХААУГ-ын удирдлагаар тухайн үед Чимидцэрэн, Дэжидбал, Д.Дашзэвгэ, Ө.Дашдаваа, Цэнд-Аюуш, Д.Батмөнх нар ажиллаж байсан.

1967 онд ХААУГ-ын зоо мал эмнэлгийн тасаг, 1972 онд Мал эмнэлгийн тасаг, 1995 онд аймгийн мал эмнэлгийн алба, ХАА сайдын 1998 оны тушаалаар аймгийн Мал эмнэлгийн газар, Мал үржлийн албыг нэгтгэн аймгийн Хөдөө аж ахуйн газар болгож бүтэц зохион байгуулалтыг өөрчлөлт хийсэн юм.

Орон нутагт тулгарч буй ажлын шаардлага, мэргэжлийн албадын санал хүсэлтийн дагуу Хөдөө аж ахуйн Сайдын 1999 А/85 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйн газар, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А-170 дугаар тушаалаар Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А-18 тоот тушаалаар үйлдвэр, хөдөө аж ахуйн газар, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А-209 тоот тушаалаар Хүнс, хөдөө аж ахуйн газар нэртэйгээр бүтэц орон тоогоор зохион байгуулагдаж үйл ажиллагаа нь жигдэрч эхэлсэн.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хуулиуд батлагдан мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан 2019 оны 1-р сарын 1-ний өдрөөс аймгийн Мал эмнэлгийн газар нь тусдаа бие даасан бүтэц орон тоо бүхий шинээр агентлаг байгуулагдан ажиллаж эхэлсэн.

2019 оноос одоог хүртэл Хүнс, хөдөө аж ахуйн газар нь эрхлэх асуудлыгаа хүрээнд Захиргаа аж ахуйн алба, Мал үржлийн алба, Үйлдвэр худалдаа үйлчилгээний алба, Хяналтын алба 4 алба 22 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Мэргэжлийн хяналтын газар татан буугдаж зарим чиг үүрэг Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжин ирсэнтэй холбогдуулан чиг үүргийн дагуу хяналтын албыг 2023 оноос эхлэн бүтцэд шинээр нэмэгдсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн салбарыг тогтвортой төлөвшүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангах”

зорилготойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд тус газарт хэрэгжиж буй 50 гаруй хууль, Засгийн газар, УИХ-ын 20 гаруй тогтоолуудыг мөрдөгддөг. Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт-Малын эрүүл мэнд” хөтөлбөрийг 2017-2020 оныг дуустал, “Зах зээл ба бэлчээрийн эрсдлийн удирдлага” төслийг 2018-2021 оныг дуусталх хугацаанд аймгийн хэмжээнд орон нутаг хариуцсан ажилтнуудтай хамтарч амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

Мөн Азийн хөгжлийн банкны "Тэжээлийн тогтвортой менежмент" төсөл, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА төслөөс хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих” төсөл, Дэлхийн банкны МАА-ЭЗЭН төсөл, Азийн хөгжлийн банкны төсөл, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага, Шинэ хөдөө төсөл зэрэг гадаадын 10 гаруй төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч, орон нутгийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд үр дүнтэй ажилласаар ирлээ.

Тус байгууллага нь Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, орон нутгийн онцлогт тохирсон дэвшилтэд технологи бүхий үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэн аймгийнхаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох зорилготойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд тухайн салбарт хэрэгжиж буй 70 гаруй хууль, УИХ, Засгийн газрын 30 гаруй тогтоол, аймгийн ИТХ-аас баталсан 6 тогтоолыг мөрдөж орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮЕ ҮЕИЙН УДИРДЛАГУУД

Дд	Ажиллаж байсан он	Овог нэр	Мэргэжил
1	1997-1998	Содномын Батсайхан	Малын их эмч
2	1998-1999	Цогвоогийн Гэрэл	Малын их эмч
3	1999-2000	Шатарын Энхбат	Малын их эмч
4	2000-2010	Жамбын Хүүхэнбаатар	/Малын их эмч
5	2010-2014	Мэндбаярын Мөнхжаргал	Малын их эмч
6	2014-2017	Гаваагийн Дашбалдан	Малын их эмч
7	2017-одоог хүртэл	Баатарын Мөнхжаргал	Эдийн засагч

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэхээр гарсан хууль, тогтоомжийг баримталж хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг санаачлан орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж 21 аймгаасаа улсдаа 2020 онд 5-р байр, 2021 онд 3-р байранд 2023 онд 6-р байранд шалгарч ажлын үзүүлэлтээрээ тэргүүлэн ажиллаа.

Энэ хугацаанд хэрэгжүүлсэн томоохон ажлын үр дүн бол Дундговь аймаг түүхэндээ анх удаа Нутгийн омог"-ийн малтай болж, монгол улсын шинээр зохион бүтээсэн мал, амьтны бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авсан нь нутгийн мал сүргийн чанарыг сайжруулах, малчдын ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чухал ажил болсон.

ДУНДГОВЬ АЙМАГТ ҮРЖҮҮЛЭГДЭЖ БУЙ ОМГИЙН МАЛЫН ТАНИЛЦУУЛГА

1. ӨНДӨРШИЛ ОМГИЙН АДУУ

ХХААХҮЯамны сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/445 тоот тушаалаар Өндөршил суманд үржүүлэгддэг **Хурд-Махны** чиглэлийн **“Өндөршил”** омгийн адууг анх удаа батлуулсан. бэлчээрийн ургамлын шимт чанар сайн, уургийн агууламж өндөр байдагтай холбоотой юм.

Өндөршил адуу нь манай орны говь, тал хээрийн бүсэд дасан зохицсон тарга хүч сайн авдаг, галбир бие цогцосын хувьд ямар нэгэн согог дутагдалгүй жилийн дөрвөн улиралд байгалийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд бэлчээрийг бүрэн ашиглаж өсөж үрждэг, амьдрах чадвар, тэсвэр хатуужил, биеийн ерөнхий хөгжил сайтай толгой дух өргөн, шулуун хамартай, хүзүү богиновтор, босоодуу дунд зэргийн мундаатай, харьцангуй урт биетэй, өргөн цээжтэй, өвчүү нь гадагшаа мэдэгдэхүйц төвийсөн, нуруу шулуун шөрмөслөг богино чацтай, цомбон туурайтай, шингэвтэр дэл сүүлтэй, чийрэг бие цогцостой, үр төлдөө удамшилаа бүрэн дамжуулдаг, нийт адууны 57 орчим хувь нь цагаан, бор, шарга, хул хонгор зүстэй байдаг.

Адууны үс тачир, арьс нимгэн, 1 мм² талбайд ногдож буй уутанцар цөөн, үсний ширхэгт голч нь бусад үүлдэр, омгийн адуутай харьцуулахад 8-12 мкм-ээр нимгэн байгаа нь хурдлах чадвар өндөр болохыг илтгэж байна. Өндөршил адууны сагагны урт 7-9 см, зай багатай, шилбэ том бадриун тул давхилын үед хөл авах явдал бараг гардаггүй, эрүү хоорондын зай их, амьсгалын тоо, цусан дахь уургийн агууламжаараа монгол адуунаас 4.5-6.0 хувь илүү байгаа нь хурдлах чадвар сайтай, тэсвэр хатуужилтайг нотолж байна. Өндөршил адууг Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуунд одоогоос 100-аад жилийн өмнө ардын селекцийн аргаар бий болгож Өндөршил сумаас гадна өөрийн аймгийн бүх суманд сайжруулагчаар ашиглаж байгаагийн гадна монгол орны төв, говийн бүсийн сайжруулагчаар ашиглаж хурдны чиглэлээр ашиглаж байна. Өндөршил омгийн адуунаас Аймаг баяр наадам, Улсын бүс, Улсын наадам, Их хурд зэрэг томоохон наадамд 50 гаруй айраг түрүүг хүртсэн. “Улсын шилмэл мал-2019” арга хэмжээнд Өндөршил омгийн адуугаар оролцож Азарга Дэд байр, Гүү Тэргүүн байрыг тус тус эзэлсэн. Өндөршил омгийн адууны Омгийн тодорхойлолтыг Аймгийн ерөнхий мал зүйч, Монгол улсын тэргүүлэх мал зүйч Ж.Батбилэг, аймгийн ерөнхий мал зүйчээр ажиллаж байсан ХХААГ-ын Мал үржлийн албаны дарга Т.Мөнхбат, МААЭШХ-ийн дэд захирал Б.Бейсэн, Өндөршил сумын засаг даргын орлогч дарга Л.Мөнхбадрах нар удирдан зохион байгуулсан.



2. ОЛДОХЫН ХҮРЭН БОР ОМГИЙН ТЭМЭЭ

ХХААХҮЯамны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А-358 тоот тушаалаар Хулд суманд үржүүлэгддэг **Мах-Ноосны чиглэлийн “Олдохын хүрэн бор”** омгийн тэмээг баталсан. Олдохын хүрэн бор тэмээний гол нутаг, бэлчээр нь Үл Олдохын тал хэмээх өргөн уудам нутаг юм. Энэ хөндийд хувьсгалаас өмнө биеэ даасан 300 гаруй ламтай хийд оршин тогтнож, хийдийн торгон сүрэг нь тэмээ байсан учир жасын мал сүрэг, бурханы сүрэг хэмээн нэрлэж байсан нь одоогийн “Олдохын хүрэн бор” тэмээний үндэс тавигдсан түүхтэй. “Олдохын хүрэн бор” тэмээ нь манай орны говь, тал хээрийн бүсэд зохицсон, тарга хүч сайн авч жилийн аль ч улиралд болон цагийн хатуу, байгалийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд бэлчээрийг бүрэн ашиглаж, өсөж үржих, амьдрах чадвар тэсвэр хатуужил сайтай мал юм.

Нийт сүргийн 60.6 хувь нь хүрэн бор, тэмээний ноосон ашиг шим нас гүйцсэн буур болон атны ноосны гарц дунджаар 11.39 кг, ингэнийх 6.26 кг, 3-4 настай тайлагных 6.76 кг, гунжных 5.32 кг, эр торомных 3.64 кг, охин торомных 3.32 кг байна.

Олдохын хүрэн бор тэмээний намрын амьдын жин Олдохын хүрэн бор тэмээний намрын амьдын жин ингэ 491-736 кг, буур, атан тэмээ 694-950 кг, тором 253-357 кг, 3-4 настай өсвөр тэмээ 361-562 кг байгаа нь бусад үүлдрийн монгол тэмээтэй харьцуулахад буур 120-150 кг, ингэ 75-90 кг-аар илүү байна.

Олдохын хүрэн бор омгийн тэмээгээр Алтанбулаг, Бээжин, Шанхай Хужирбулан зэрэг газруудад жин тээж, хоршооны бараа, хүнс татан,уулнаас мод хүртэл татах ажлыг намрын эхэн сараас өвлийн дунд сар хүртэл 3-5 сар транзит тээвэр хийдэг байжээ.

“Талын цэцэг” нэгдэл гэж байхад ээлжийн ингэнээс гарсан ботгоо бүрэн бойжуулж сүү үйлдвэрлэлийн даалгавраа тэмээчин бүр хангаж 2500-3000 л сүү ашиглаж ашиг шим үйлдвэрлэлийн даалгаврыг 100-115%-иар биелүүлж ХХААЯ-аас зарласан болзолт уралдаанд 3-н жил дараалан тэргүүлж нэгдэлдээ Зил-130, Газ-53 машинаар шагнуулж байсан юм. Тэмээчид нь ашиг, шим үйлдвэрлэлийн даалгавраа 100-аас дээш хувиар биелүүлж, ээлжийн ингэнээс хүлээн авах ботгыг 100% бойжуулж, тэмээний зүй бус

хорогдол гаргалгүй хөдөлмөрлөж 5 жилийн хугацаанд БНМАУ-ын аварга малчин 5, Мөнгөн буурны эзэн 3, Аймгийн ашиг шимийн аварга 8, Мөнгөн буйлны эзэн 1, төрөн гарсан нь тэмээчдийн уйгагүй зүтгэл байсан юм. Улсын шилмэл мал-2015 арга хэмжээнд оролцож буур дэд байр, ингэ нийслэлийн шилмэл мал тэргүүн байр, Улсын шилмэл-2019 арга хэмжээнд буур тэргүүн байр, ингэ дэд байруудад тус тус шалгарч байсан. Олдохын хүрэн бор тэмээний тодорхойлолтийг Аймгийн ерөнхий мал зүйч, Монгол улсын тэргүүлэх мал зүйч Ж.Батбилэг, Монгол улсын зөвлөх мал зүйч Х.Бүүвэйбаатар, Монгол улсын зөвлөх мал зүйч Доктор Г.Сувдаа, Мал зүйч Б.Сангад нар удирдан зохион байгуулсан.



3. САЙНЦАГААН ОМГИЙН ХОНЬ

Сайнцагаан хонь нь сумын Наран, Тэвш, Далай, Үйзэн багуудад тархан үржүүлэгдэж байгаа бөгөөд тус хонины цөм сүрэг нь Далай багт голлон үржүүлэгдэж байна. Сайнцагаан сумын Далай багт ширүүн ноост монгол хонийг сайжруулах ажил хийгдээгүй цэврээр үржүүлж ирсэн. Говь, тал хээр хосолсон нутгаар тархсан жилийн дөрвөн улиралд зохицож амьдрах чадвартай.

Сайнцагаан хонины хүзүү махлаг, дунд зэргийн урттай, арьс нь нягт үрчлээсгүй, сэрвээ махлаг өргөн, нуруу ууц нь харьцангуй өргөн, махлаг, тэгш шулуун байна. Сайнцагаан хонины үргэлж ноосонд зунгагийн эзлэх хувийн жин энэхүү сүрэгт 84-91.7 байгаа нь тухайн ашиг шимийн технологийн чанарыг хадгалахаас гадна хүчтэй салхи, шуурагатай үед хонины ноос ярагдаж биеийн дулаанаа алдахаас хамгаалах ач хобогдолтой. Сайнцагаан омгийн бүдүүн хуц 1.9 кг, төлгөн хуц 1.6 кг, эм хонь 1.6 кг, охин төлөг 1.4 кг ноос өгдөг ба бусад үүлдэр омгийн хониноос 0.5-0.8 кг илүү байдаг. Сайнцагаан хонины 63.7–79.5% нь чийрэг бие цогцостой, 57.2 % нь хар халзан, хар нүдэн, 75.8-84.3% нь дунд зэрэг өргөгдсөн том өөхөн сүүлтэй биерхэг хонь юм. Сайнцагаан хонин сүргийн дотор жин ихтэй, ноосны гарц болон чанарын хувьд үйлдвэрийн стандарт, чанарын шаардлагыг хангаж байгаа нь сүргийн чанарыг сайжруулж, үр төлдөө удамшуулан үлдээн хадгалахад гол үүрэгтэй юм. Хонины маханд дунджаар уураг, 16-18%, өөх тос 9-32%, чийг 51-70%, үнс 0.7-0.8%, бага насны хонины маханд шүүс их байна. Сайнцагаан хониний ноосны 51.9% ноолуур, 8.2% завсрын үс, 12.3% сор үс, 21.4% ямаан үс эзэлдэг. Улсын шилмэл мал 2012 арга хэмжээнд эм хонь дэд байр, Улсын

шилмэл мал 2013 арга хэмжээнд хуц тэргүүн байр, Улсын шилмэл мал 2015 арга хэмжээнд хуц тэргүүн байр, Улсын шилмэл мал 2019 арга хэмжээнд хуц тусгай байр тус тус эзэлж байсан. Сайнцагаан омгийн хониний тодорхойлолтыг Монгол улсын зөвлөх мал зүйч, дэд профессор Н.Сүхээ /Ph.D/, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Нарантуяа /Ph.D/, МЭҮТасгийн мэргэжилтэн Р.Булгантамир нар удирдан зохион байгуулсан.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРСӨН УЛСЫН САЙН МАЛЧИН, ХӨДӨЛМӨРИЙН
БААТАР, ГАВЪЯАТ МАЛЧДЫН НЭРС**

д/д	Малчны овог, нэр	Цол, шагналын нэр	Цол шагнал авсан огноо	Байнга оршин суудаг хаяг/сум баг/
МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР				
1	Намхайн Ичинхорлоо	Хөдөлмөрийн баатар	1964	Эрдэнэдалай сум 3-р баг
2	Дунжмаагийн Цэнд	Хөдөлмөрийн баатар	1964	Өлзийт сум
3	Цэрэндорж Давга	Хөдөлмөрийн баатар	1986	Эрдэнэдалай сум 5-р баг
4	Бямба Дашзэвгэ	Хөдөлмөрийн баатар	1989	Адаацаг сум Ар-урт баг
5	Банзрагч Эс	Хөдөлмөрийн баатар	1964	Хулд сум Олдох баг
МОНГОЛ УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН				
1	Д. Батгэрэл	Улсын хошой аварга малчин	2018	Дэрэн
2	Г. Сампил	Улсын хошой аварга малчин	2019	Эрдэнэдалай
4	Г.Бүдсүрэн	Улсын хошой аварга малчин	2022	Адаацаг
3	Жасрайн Одонпүрэв	Улсын хошой аварга малчин	2023	Дэрэн
ГАВЪЯАТ НЭГДЭЛЧИН УЛСЫН АВАРГА ХОШОЙ МАЛЧИН				
1	Тулга Дагдан	Гавъяат нэгдэлчин Улсын аварга хошой малчин	1979 он 1964-1977 он	Луус сум Суварга баг
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ МАЛЧИН				
1	Жамба Дашзэвгэ	Монгол Улсын гавъяат малчин	2007	Адаацаг Өвөр-Урт баг
2	Хоомон Баянжаргал	Гавъяат малчин	1990	Өлзийт сум 4-р баг
3	Хандсүрэн Отгон	Гавъяат малчин	2006	Өлзийт сум 5-р баг
МОНГОЛ УЛСЫН САЙН МАЛЧИН, АВАРГА МАЛЧИН				

1	Долгор Баатархүү	Улсын сайн малчин	2000	Говь-Угтаал сум Хонгор баг
2	Данзанчүтэм Өлзийбүрэн	Улсын сайн малчин	2003	Говь-Угтаал сум Хонгор баг
3	Банзрагч Сүрэндаваа	Улсын сайн малчин	2009	Говь-Угтаал сум Морьт баг
4	Вандан Нямдорж	Улсын сайн малчин	2010	Говь-Угтаал сум Ажирхай баг
5	Наваантая Жаргалсайхан	Улсын сайн малчин	2011	Говь-Угтаал сум Ажирхай баг
6	Лувсанжав Батсайхан	Улсын сайн малчин	2013 он	Луус сум Буянт баг
7	Дамбий Даржааюу	Улсын сайн малчин	2004 он	Луус сум Суварга баг
8	Даваа Бүдханд	Улсын сайн малчин	2007 он	Луус сум Суварга баг
9	Дуламсүрэн Гантөмөр	Улсын сайн малчин	2010	Дэлгэрцогт 2-р баг Цахирын уул
10	Самбуу Оюунтуяа	Улсын сайн малчин	2012	Цагаандэлгэр сум 2-р баг /Дэлгэрэх зам/
11	Гомбодорж Сампил	Улсын сайн малчин	2001	Эрдэнэдалай сум 4-р баг
12	Дамбажамц Дуламсүрэн	Улсын сайн малчин	2005	Эрдэнэдалай сум 2-р баг
13	Шаравдорж Шагдар	Улсын сайн малчин	2007	Эрдэнэдалай сум 4-р баг
14	Очир Мөнхбат	Улсын сайн малчин	2008	Эрдэнэдалай сум 6-р баг
15	Цэрэнпэл Маналжав	Улсын сайн малчин	2009	Эрдэнэдалай сум 4-р баг
16	Доржсамба Юндэн	Улсын сайн малчин	2010	Эрдэнэдалай сум 4-р баг
17	Найдан Лхасүрэн	Улсын сайн малчин	2014	Эрдэнэдалай сум 4-р баг
18	Бямба Дашзэвгэ	Улсын сайн малчин	1981	Адаацаг сум Ар-урт баг
19	Жамба Дашзэвгэ	Улсын сайн малчин	1993	Адаацаг Өвөр-Урт баг
20	Базарсүрэн Баасанжав	Улсын сайн малчин	2007	Адаацаг Хашаат баг
21	Жумба Банди	Улсын сайн малчин	2009	Адаацаг сум Ар-урт баг
22	Галя Бүдсүрэн	Улсын сайн малчин	2013	Адаацаг сум Сүм баг
23	Содном Дашдорж	Улсын сайн малчин	1990	Өлзийт сум

24	Гарам Самбалхүндэв	Улсын сайн малчин	1996	Хулд сум
25	Батдэлгэр Доржжамц	Улсын сайн малчин	1994	Хулд сум
26	Рулам Ойровдорж	Улсын сайн малчин	2012	Хулд сум
27	Шаравжамц Нармандах	Улсын сайн малчин	2002 он	Сайнцагаан сум 2-р баг
28	Үржин Чимэд- Очир	Улсын сайн малчин	2013 он	Сайнцагаан сум 2-р баг
29	Доржпалам Батгэрэл	Улсын сайн малчин	2005	Дэрэн сум 4-р баг
30	У.Цэрэндорж	Улсын сайн малчин	1993	Говь-сүмбэр аймагт
31	Дондогдорж Болдбат	Улсын сайн малчин	2005	Баянжаргалан 1-р баг
32	Тавхай Дондов	Улсын сайн малчин	1997	Гурвансайхан элгэн баг
33	Цэнд Пүрэвбаатар	Улсын сайн малчин	2009	Гурвансайхан элгэн баг
34	Донтор Сэрж	Улсын сайн малчин	1996	Гурвансайхан сум 1-р баг
35	Дондов Дашдорж	Улсын сайн малчин	2010	Гурвансайхан сум 1-р баг
36	Донтор Дүгэр	Улсын сайн малчин	2011	Гурвансайхан сум 1-р баг
37	Галя Бүдсүрэн	Улсын сайн малчин	2012	Адаацаг
38	Үржин Чимэд- Очир	Улсын сайн малчин	2012	Сайнцагаан
39	Найдан Лхасүрэн	Улсын сайн малчин	2013	Эрдэнэдалай
40	Л.Батсайхан	Улсын сайн малчин	2013	Луус
41	Д.Дашжамц	Улсын сайн малчин	2014	Өлзийт
42	Ш.Мишигтаяа	Улсын сайн малчин	2014	Дэрэн
43	Л.Эрдэнэбаяр	Улсын сайн малчин	2014	Дэлгэрцогт
44	Б.Жаргалсайхан	Улсын сайн малчин	2014	Сайнцагаан
45	Б.Цэндбаяр	Улсын сайн малчин	2014	Эрдэнэдалай
46	Б.Адъяадорж	Улсын сайн малчин	2014	Сайхановоо
47	Т.Мөнхбат	Улсын сайн малчин	2015	Эрдэнэдалай
48	Дамбий Амаржаргал	Улсын сайн малчин	2015	Адаацаг
49	Баавгай Насан	Улсын сайн малчин	2015	Өлзийт
50	Г.Баатарчулуун	Улсын сайн малчин	2015	Сайхановоо
51	С.Мянганбаатар	Улсын сайн малчин	2015	Сайнцагаан
52	Б.Нямсүрэн	Улсын сайн малчин	2015	Говь-Угтаал

53	Ц.Бүд	Улсын сайн малчин	2015	Гурвансайхан
54	Намсрай Сумъяа	Улсын сайн малчин	2015	Өндөршил
55	Шар Ганхуяг	Улсын аварга малчин	2016	Сайнцагаан
56	Б.Тагарваа	Улсын аварга малчин	2016	Дэлгэрцогт
57	Б.Эрдэнэбаяр	Улсын аварга малчин	2016	Дэрэн
58	Нацаг Ганхуяг	Улсын аварга малчин	2016	Гурвансайхан
59	Ёндонжамц Өлзийбат	Улсын аварга малчин	2016	Адаацаг
60	Жалбуу Батсайхан	Улсын аварга малчин	2017	Адаацаг
61	Содном Баатар	Улсын аварга малчин	2017	Луус
62	Ёндон Дашжамц	Улсын аварга малчин	2017	Өндөршил
63	Жасрай Одонпүрэв	Улсын аварга малчин	2017	Дэрэн
64	Лувсан Бархас	Улсын аварга малчин	2017	Гурвансайхан
65	Сүрэндаваа Баянмөнх	Улсын аварга малчин	2018	Говь-Угтаал
66	Батпүрэв Цолмонбаатар	Улсын аварга малчин	2018	Баянжаргалан
67	Мөнхбаяр Галбадрах	Улсын аварга малчин	2018	Эрдэнэдалай
68	Лүндэг Өлзийбат	Улсын аварга малчин	2018	Хулд
69	Дагва Сайнбаяр	Улсын аварга малчин	2019	Цагаандэлгэр
70	Балдан Балдорж	Улсын аварга малчин	2019	Дэлгэрцогт
71	Алтангэрэл Бараахас	Улсын аварга малчин	2019	Гурвансайхан
72	Халтар Цолмонбаяр	Улсын аварга малчин	2019	Баянжаргалан
73	Жаргал Рэгзэн	Улсын аварга малчин	2019	Баянжаргалан
74	Дашдондог Ойдов	Улсын аварга малчин	2019	Сайхан-Овоо
75	Цээнпил Шатар	Улсын аварга малчин	2019	Сайнцагаан
76	Гончиг Отгонбаатар	Улсын аварга малчин	2019	Эрдэнэдалай
77	Шаравдорж Энхамгалан	Улсын аварга малчин	2020	Адаацаг
78	Намжирмаа Чинбат	Улсын аварга малчин	2020	Өндөршил
79	Ишцог Баярсайхан	Улсын аварга малчин	2020	Дэлгэрхангай
80	Зундуйжамц Бямба	Улсын аварга малчин	2020	Сайнцагаан

81	Рэнчингочоо Амгаланбаатар	Улсын аварга малчин	2020	Цагаандэлгэр
82	Ишгэн Баттөмөр	Улсын аварга малчин	2021	Баянжаргалан
83	Батсуурь Баянмөнх	Улсын аварга малчин	2021	Цагаандэлгэр
84	Лхагва Рашзэвэг	Улсын аварга малчин	2021	Эрдэнэдалай
85	Цэгмид Мөнхбаяр	Улсын аварга малчин	2021	Эрдэнэдалай
86	Э.Болор-Эрдэнэ	Улсын аварга малчин	2022	Сайхан-Овоо
87	Ц.Батжаргал	Улсын аварга малчин	2022	Өлзийт
88	Б.Цогтбаатар	Улсын аварга малчин	2022	Хулд
89	Г.Гансүх	Улсын аварга малчин	2022	Дэлгэрцогт
90	П.Энхбат	Улсын аварга малчин	2022	Эрдэнэдалай
91	Б.Дуламрагчаа	Улсын аварга малчин	2022	Эрдэнэдалай
92	С. Сүхбаатар	Улсын аварга малчин	2023	Баянжаргалан
93	Г.Ганбаатар	Улсын аварга малчин	2023	Говь-Угтаал
94	Х.Ганболд	Улсын аварга малчин	2023	Хулд
95	Г.Батчулуун	Улсын аварга малчин	2023	Дэлгэрцогт
96	Ш.Мөнхбат	Улсын аварга малчин	2023	Сайнцагаан
97	Я.Энхболд	Улсын аварга малчин	2023	Адаацаг
98	Н.Болдбаатар	Улсын аварга малчин	2023	Дэрэн
99	Б.Одхүү	Улсын аварга малчин	2023	Луус

УЛСЫН АВАРГА СААЛЬЧИН

1	Чүлтэмжамц Наранцэцэг	улсын аварга саальчин	2018	Дэрэн
2	Дашдаваа Хорлоо	Улсын аварга саальчин	2019	Гурвансайхан
3	Тавхай Дулам	Улсын аварга саальчин	2021	Гурвансайхан
4	Ё.Хонгорзул	Улсын аварга саальчин	2022	Гурвансайхан

АЙМГИЙН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ

Д/д	Сумын нэр	Овог, нэр	Он	
1	Рандан Мужил	Аймгийн тэргүүний тариаланч	2018	Сайнцагаан
2	Чогжмаа Доржпүрэв	Аймгийн тэргүүний тариаланч	2019	Дэлгэрцогт
3	Ёндон Сугар	Аймгийн тэргүүний тариаланч	2020	Сайнцагаан
4	Базарбядрин Баянмөнх	Аймгийн тэргүүний тариаланч	2021	Адаацаг
5	Н.Цэнд-Аюуш	Аймгийн тэргүүний тариаланч	2022	Сайнцагаан

6	Д.Тунгалаг	Аймгийн тэргүүний тариаланч	2023	Сайнцагаан
7	Х.Базарсүх	Аймгийн тэргүүний тариаланч	2023	Дэлгэрхангай

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР